**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2024/05/НА-СТА-ТТЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788

Цахим хаяг:orgil.ikhuul@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................4
Асуудлыг онцолсон хэсэг....................4
Аудитын гол асуудал....................4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....................6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................10
3.4.1 Мөнгөн хөрөнгө ....................12
3.5.2 Авлага....................12
3.5.3 Урьдчилгаа....................13
Урьдчилж төлсөн зардал гараагүй байна. ....................13
3.5.4 Бараа материал....................13
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт....................13
3.5.6 Үндсэн хөрөнгө....................14
3.5.7 Өр төлбөр....................14
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо ....................15
3.5.8 Орлогын данс....................15
3.5.9 Зардлын данс....................15
4.1 Ерөнхий зүйл ....................19
4.2 Материаллаг байдал....................19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....................20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....................20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................20
4.5.1 Завсрын аудитын талаар....................20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....................21
5.1 Зөвлөмж ....................21

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СДОА | Сум дундын ойн анги |
| УО | Урьдчилж орсон орлого |
| УТХ | Улсын тэмдэгтийн хураамж+ |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/280

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.БЯМБАЖАВ
ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 28.0 сая төгрөг, шилжүүлэн авсан 239.6 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь 7.3 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 70.9 сая төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 35 иргэнтэй холбоотой 81.3 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Жаргалант сумын Засаг дарга нь 2023 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 11 зорилт, 32 арга хэмжээний биелэлтийг 85.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

6724040758

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 613,837.8 | 1,027,721.9 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 377,484.7 | 574,553.3 |
| 33 | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 110,035.8 | 232,942.4 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 114,607.9 | 220,226.1 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 3,539,812.9 | 3,443,817.4 |
| 37 | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 11а, 11б | 190,576.5 | 81,351.8 |
| 37300 | **Урт хугацаат зээл** | | 190,576.5 | 81,351.8 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 3,349,236.4 | 3,362,465.6 |
| 39200 | **Биет хөрөнгө** | | 3,219,698.7 | 3,210,988.0 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 13 | 129,537.6 | 151,477.6 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **4,153,650.7** | **4,471,539.3** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 17,759.1 | 7,090.1 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 17,759.1 | 7,090.1 |
| 41300 | **Өглөг** | 17а, 17б | 1,785.8 | 3,305.6 |
| 41400 | **Урьдчилж орсон орлого** | 18а, 18б | 15,973.2 | 3,784.5 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 4,135,891.6 | 4,464,449.2 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | | 4,135,891.6 | 4,464,449.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 3,011,043.6 | 3,011,043.6 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 142,330.2 | 91,421.2 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | | 789,379.0 | 1,168,845.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 193,138.8 | 193,138.8 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **4,153,650.7** | **4,471,539.3** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | **1,999,971.0** | **2,728,907.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 667,081.2 | 849,999.0 |
| 110 | Орлогын албан татвар | | 301,860.2 | 377,544.6 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 323,327.9 | 404,154.4 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -21,467.7 | -26,609.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 66,069.0 | 69,370.1 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 299,152.0 | 403,084.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 81,576.6 | 267,938.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 81,576.6 | 267,938.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,251,313.2 | 1,610,969.4 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 1,870,778.5 | 2,384,495.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,870,778.5 | 2,384,495.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,822,768.5 | 2,347,244.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 407,109.9 | 506,383.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 50,264.1 | 63,280.8 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 532,206.3 | 44,908.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 65,022.6 | 73,494.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 197,205.4 | 53,124.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 2,751.0 | 6,540.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 152,024.0 | 969,499.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 415,460.2 | 630,012.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 48,010.0 | 37,251.8 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 129,192.5 | 344,411.5 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 9,401,948.7 | 1,221.1 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **-9,272,756.3** | **343,190.4** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,042,259.8 | 2,605,100.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 667,081.2 | 849,999.0 |
| 110 | Орлогын албан татвар | 301,860.2 | 377,544.6 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 323,327.9 | 404,154.4 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -21,467.7 | -26,609.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 66,069.0 | 69,370.1 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 299,152.0 | 403,084.4 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 21,583.2 | 54,724.7 |
| 1181 | Газрын төлбөр | 48,661.4 | 16,832.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 228,907.4 | 331,527.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 123,865.4 | 144,132.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 123,865.4 | 144,132.4 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,251,313.2 | 1,610,969.4 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,486,397.2 | 2,320,047.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,486,397.2 | 2,320,047.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,322,297.7 | 1,902,383.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 451,103.7 | 559,742.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,754.0 | 78,522.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 531,380.5 | 45,988.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 77,122.5 | 103,554.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 52,795.4 | 51,057.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,751.0 | 6,540.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 84,896.5 | 924,881.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,494.1 | 132,096.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 164,099.5 | 417,664.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 555,862.6 | 285,053.6 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 284,346.8 | 27,985.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 284,346.8 | 27,985.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 284,346.8 | 27,985.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -284,346.8 | -27,985.0 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -160,000.0 | -60,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 160,000.0 | 60,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 111,515.8 | 197,068.6 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 265,968.9 | 377,484.7 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 377,484.7 | 574,553.3 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 13,248,718.3 | 0.0 | 13,248,718.3 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 98,049.6 | 0.0 | 98,049.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,346,767.9 | 0.0 | 13,346,767.9 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 61,880.0 | 0.0 | 61,880.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -9,272,756.3 | 0.0 | -9,272,756.3 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,135,891.6 | 0.0 | 4,135,891.6 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,135,891.6 | 0.0 | 4,135,891.6 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,135,891.6 | 0.0 | 4,135,891.6 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | -14,632.9 | 0.0 | -14,632.9 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 343,190.4 | 0.0 | 343,190.4 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,464,449.2 | 0.0 | 4,464,449.2 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,330,468.6 | 2,057,474.5 | -363,148.6 | 88.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,249,998.6 | 1,997,474.5 | -363,148.6 | 88.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,777,617.9 | 1,592,548.8 | 16,667.1 | 89.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 523,785.1 | 504,005.7 | 0.0 | 96.2 |
| 210101 | Үндсэн цалин | 400,805.3 | 348,088.7 | 0.0 | 86.8 |
| 210102 | Нэмэгдэл | 110,254.8 | 112,374.3 | 0.0 | 101.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 210104 | Урамшуулал | 12,725.0 | 43,542.7 | 0.0 | 342.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 69,526.4 | 61,923.4 | 0.0 | 89.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,610.0 | 41,910.8 | 0.0 | 88.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,479.0 | 5,002.8 | 0.0 | 91.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,383.2 | 4,002.7 | 0.0 | 91.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,095.9 | 1,000.8 | 0.0 | 91.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,958.3 | 10,006.3 | 0.0 | 91.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 621,159.8 | 592,478.2 | 175,007.1 | 95.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,100.0 | 54,941.5 | -145.5 | 121.8 |
| 210302 | Түлш, халаалт | 554,934.8 | 520,528.4 | 175,152.6 | 93.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,125.0 | 17,008.3 | 0.0 | 80.5 |
| 210304 | Байрны түрээс | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 67,086.4 | 65,387.1 | 0.0 | 97.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,400.4 | 6,400.4 | 0.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,675.0 | 47,284.0 | 0.0 | 97.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,511.0 | 3,320.0 | 0.0 | 73.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500.0 | 4,382.7 | 0.0 | 125.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,000.0 | 4,000.0 | 0.0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 104,719.0 | 104,719.0 | -4,781.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 104,719.0 | 104,719.0 | -4,781.0 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,000.0 | 5,840.0 | 0.0 | 97.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,000.0 | 5,840.0 | 0.0 | 97.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 325,755.2 | 201,258.9 | 54,000.0 | 0.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 322,055.2 | 198,703.2 | 0.0 | 61.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,200.0 | 1,200.0 | 0.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 205.0 | 111.5 | 0.0 | 54.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 160.0 | 88.0 | 0.0 | 55.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000.0 | 1,000.0 | 0.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,135.0 | 156.2 | 0.0 | 13.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,586.0 | 56,936.5 | -207,559.0 | 95.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,086.0 | 19,436.5 | -207,559.0 | 88.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 37,500.0 | 37,500.0 | 0.0 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 472,380.7 | 404,925.8 | -379,815.7 | 85.7 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 447,270.6 | 379,815.7 | -379,815.7 | 84.9 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 447,270.6 | 379,815.7 | -379,815.7 | 84.9 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,110.1 | 25,110.1 | 0.0 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,098.1 | 23,098.1 | 0.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,012.0 | 2,012.0 | 0.0 | 100.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 69,600.0 | 60,000.0 | 0.0 | 86.2 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 69,600.0 | 60,000.0 | 0.0 | 86.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,330,468.6 | 2,266,010.5 | -632,676.7 | 97.2 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 352,971.8 | 344,971.8 | 1,805,798.0 | 97.7 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.0 | 0.0 | 1,859,798.0 | |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 352,971.8 | 344,971.8 | 0.0 | 97.7 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,629,945.8 | 1,850,464.2 | 1,173,121.3 | 113.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,629,945.8 | 1,850,464.2 | 1,518,093.1 | 113.5 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.0 | 0.0 | -344,971.8 | |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 347,551.0 | 70,574.5 | 0.0 | 20.3 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,000.0 | 64,807.2 | 0.0 | 108.0 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,400.0 | 5,767.3 | 0.0 | 50.6 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 276,151.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 50,486.8 | 2,402.4 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 73,854.8 | 12,614.3 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 0.1 | 0.0 | 0.0 | 12.7 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 0.0 | 0.0 | 0.0 | 66.7 |
| 610001 | Төсвийн байгууллага | 0.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.0 | 0.0 | 0.0 | 10.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 0.0 | 0.0 | 0.0 | 10.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0.0 | 0.0 | 0.0 | 15.4 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0.0 | 0.0 | 0.0 | 10.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 0.0 | 0.0 | 0.0 | 16.7 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 297,776.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 297,776.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 216,351.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,985.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 369.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,616.76 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,557.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,557.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 |

| | | |
|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 175,985.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 175,511.66 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 474.24 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,123.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,123.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,424.44 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,348.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,348.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 78,076.44 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 78,076.44 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 297,776.10 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 297,776.10 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,696.98 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 293,079.12 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:**

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хархэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Жаргалант сумын Засаг дарга нь 2023 оныг “Иргэдийн сэтгэл ханамжид суурилсан эрхзүйн төрийн удирдлага, иргэдийн оролцоотойгоор тогтвортой хөгжих дэд бүтэц, хөдөө аж ахуйн байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, иргэдийн хүсэлт сонирхолд тулгуурласан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хөнгөн үйлдвэрийн бодлого, иргэддээ ээлтэй аюулгүй байдлын бодлого, ил тод төсөв санхүүгийн бодлогыг дэвшүүлэх” жил болгон зарласан байна.

Жаргалант сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 2 төсөвт байгууллага, 2 орон нутгийн сан, нийт 5 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс гүйцэтгэлээр санхүүжиж байгаа улсын төсвийн байгууллагуудад олгосон тогтмол зардалтай холбоотой санхүүжилтийг Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу Засаг даргын 2021 оны 04 сарын 30 өдрийн А/70 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний шатахууны зарцуулалт, өмч хөрөнгийн бүртгэл,тооллого,ашиглалт, хамгаалалт, шилэн дансны мэдээлэл зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 317.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 377,484.7 | 574,553.3 | 197,068.6 |
| Авлага | 110,035.8 | 232,942.4 | 122,906.6 |
| Бараа материал | 114,607.9 | 220,226.1 | 105,618.2 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 190,576.5 | 81,351.8 | (109,224.7) |
| Үндсэн хөрөнгө | 3,349,236.4 | 3,362,465.6 | 13,229.2 |
| **Нийт хөрөнгө** | **4,153,650.7** | **4,471,539.3** | **317,888.6** |
| Өр төлбөр | 17,759.1 | 7,090.1 | (10,669.0) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,135,891.6 | 4,464,449.2 | 328,557.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,153,650.7** | **4,471,539.3** | **317,888.6** |

*Эх сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан*

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс, авлага данс, бараа материал данс, үндсэн хөрөнгө данс нэмэгдэж, урт хугацаат хөрөнгө оруулалт данс буурсан үзүүлэлттэй байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 540.2 сая төгрөг болж, өмнөх оноос 29.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах | 363,073 | 569,647.5 | 206,574.5 |
| Арилжааны банк дахь харилцах | 14,411.7 | 4,905.8 | (9,505.9) |
| **Дүн** | **377,484.7** | **574,553.3** | **197,068.6** |

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийн 569.6 сая төгрөг нь төрийн сангийн дансанд, 4.9 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Мөнгөн хөрөнгө 197.0 сая төгрөгөөр өсөж 574.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 495.8 сая төгрөг, ОНХСангийн үлдэгдэл 61.2 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 12.6 сая төгрөг, Эрчимт идэр СДОАнгийн дансны үлдэгдэл 4.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 495.8 сая төгрөг болж өсөхөд самар олборлох эрхийн дуудлага худалдааны дэнчингийн мөнгө 78.0 сая төгрөг, самрын орлого ороход дагалдах УТХ-ийн орлого 105.2 сая төгрөгөөр давсан нь нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт*

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 232.9 сая төгрөг болж, өмнөх оноос 122.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 0 | 0 | 0.0 |
| Зээлийн хүүгийн авлага | 7,286.3 | 8,844.7 | 1,558.4 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 0 | 135.4 | 135.4 |
| Байгууллагаас авах авлага | 3,735.6 | 22,466.4 | 18,730.8 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгосон зээл /ААН/ | 55,208.3 | 147,752.1 | 92,543.8 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 43,714.4 | 53,743.9 | 10,029.5 |
| **Дүн** | **110,035.8** | **232,942.4** | **122,906.6** |

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан

Авлага 122.9 сая төгрөгөөр өсч, 232.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 210.3 сая төгрөг, Эрчимт идэр СДОА-ийн авлагын үлдэгдэл 0.1 сая төгрөг, ИТХ-ын үлдэгдэл 8.0 сая төгрөг, ОНХС 14.5 сая төгрөг үлдэгдэлтэй байна. Хоршоо хөгжүүлэх сангийн богино хугацаат авлага нэмэгдсэн нь урт хугацаат зээлийн авлагаас 109.2 сая төгрөгөөр богино хугацаат авлага руу шилжүүлж бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:* Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэл 117.0 сая төгрөгөөс 64.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 35 иргэнтэй холбоотой 81.3 сая төгрөгийн авлага байна. Үүнээс: 5 иргэний 17.2 сая төгрөгийн зээл шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд, 4 иргэний 15.7 сая төгрөгийн зээл шүүхийн шатанд хүргүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."*орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилж төлсөн зардал гараагүй байна.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 220.2 сая төгрөг болж, өмнөх оноос 105.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бэлэн бүтээгдэхүүн | 14,203.4 | 27,448.9 | +13,245.5 |
| Эм боох материал | 11,023.4 | 11,023.4 | 0 |
| Бичиг хэргийн материал | 1,729.0 | 930.0 | -799.0 |
| Аж ахуйн материал | 4,986.2 | 7,841.5 | 2,855.3 |
| Барилгын материал | 3,199.0 | 3,199.0 | 0 |
| Бусад хангамжийн материал | 79,466.9 | 143,783.4 | 64,316.5 |
| Мал амьтад | 0 | 26,000.0 | 26,000.0 |
| **Дүн** | **114,607.9** | **220,226.1** | **105,618.2** |

*Эх сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх онд 114.6 сая төгрөг байсан бөгөөд бэлэн бүтээгдэхүүн 13.2 сая төгрөгөөр, йж ахуйн материал 2.8 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 64.3 сая төгрөгөөр, мал амьтад 26.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бичиг хэргийн материалын үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр буурч үлдэгдэл 220.2 сая төгрөг болсон байна.

Бараа материал дансны үлдэгдэл 105.6 сая төгрөгөөр өсч 220.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба ЗДТГ-т ойн хандиваар 66.4 сая төгрөгийн хангамжийн материал орлогод авсан, ОНХС-ийн хөрөнгөөр 26.0 сая төрөгийн мал худадан авсан, Эрчимт идэр СДОА-ийн дуусаагүй үйлдвэрлэл данс 13.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

**3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 87.5 сая төгрөг болж, өмнөх оноос 0.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Хувь хүмүүст олгосон зээл | 190,576.5 | 81,351.8 | -109,224.7 |
| **Дүн** | **190,576.5** | **81,351.8** | **-109,224.7** |

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 190.6 сая төгрөг байсан бөгөөд 109.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн урт хугацаат зээлээс богино хугацаат авлагаар шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

*<u>Аудитын илрүүлэлт</u>*

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

**3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,362.5 сая төгрөг болж, өмнөх оноос 13.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **3,219,698.7** | **3,210,988.0** | **-8,710.7** |
| Барилга, байгууламж, орон сууц | 3,219,176.0 | 3,249,643.9 | 30,467.9 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 413,557.3 | 433.953.2 | 20,395.9 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 188,313.4 | 202,214.6 | 13,901.2 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,939.7 | 33,887.9 | 6,948.2 |
| Зам гүүрийн байгууламж | 32,000.0 | 32,000.0 | 0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 158,263.0 | 257,338.4 | 99,075.4 |
| **Биет бус хөрөнгө** | **129,537.6** | **151,477.6** | **21,940.0** |
| Программ хангамж | 4,080.4 | 3,067.0 | -1,013.4 |
| Бусад биет бус хөрөнгө | 129,452.6 | 151,452.6 | 22,000.0 |
| **Дүн** | **3,349,236.3** | **3,362,465.6** | **13,229.3** |

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,362.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 28.0 сая төгрөг, шилжүүлэн авсан 239.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийг акталж устгасан 23.7 сая төгрөг, Эрчимт идэр СДОА-ийн 50.9 сая төгрөгийн машиныг Аймгийн Байгаль орчны газарт шилжүүлсэн, тайлант хугацааны 228.3 сая төгрөгийн элэгдлийн зардал үндсэн хөрөнгийн үдэгдэлд нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 17.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7.1 сая төгрөг болж, 10.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
|---|---|---|---|
| Татаас, санхүүжилт, шилжүүлэг өглөг | | | |
| Байгууллагад төлөх өглөг | 17,759.1 | 7,090.1 | 10,669.0 |
| **Богино хугацаат өр төлбөр дүн** | **17,759.1** | **7,090.1** | **10,669.0** |

*Эх сурвалж:Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр данс нь 10.6 сая төгрөгөөр буурч, 7.1 сая төгрөгний өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангаас Хөвсгөл зам ХХК-д өгөх 1.8 сая төгрөг, Эрчимт идэр СДОАнги 1.5 сая төгрөгийг БОАЖЯ-ны Уур амьсгалын санд өгөх үнэт цаасны үнэ, оны эцэст шилжиж ирсэн урьдчилгаа санхүүжилтыг УО-оор бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,135.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,464.4 сая төгрөг болж, 328,6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 3,011,043.5 | 3,011,043.5 | 0 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 142,330.2 | 91,421.1 | -50,909.1 |
| Хуримтлагдсан үр дүн | 789,379.0 | 1,168,845.6 | 379,466.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 193,138.8 | 193,138.8 | 0 |
| **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** | **4,135,891.6** | **4,464,449.2** | **328,557.6** |

*Эх сурвалж:Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 328.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 379.5 сая төгрөгийн өсөлтөд , Эрчимт идэр сум дундын ойн ангийн 2ширхэг фурган данснаас хассан дүн 50.9 сая төгрөг нөлөөлсөн байна.

### 3.5.8 Орлогын данс

Тусламж санхүүжилтийн орлого 1,679.6 сая төгрөг, татварын орлого 850.0 сая төгрөг, татварын бус орлого 144.1 сая төгрөг, нийт орлогын дүн 2,673.7 сая төгрөг болж өмнөх оноос 130.9 хувиар өссөн байна.

Хүснэгт № 9. Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Татварын орлого | 667,081.2 | 849,999.0 | 182,917.8 | 127.4 |
| Татварын бус орлого | 81,576.6 | 267,938.9 | 186,362.3 | 132.8 |
| Тусламж санхүүжилтийн орлого | 1,251,313.2 | 1,610,969.4 | 359,656.2 | 128.7 |
| **Нийт дүн** | **1,999,971.0** | **2,728,907.4** | **728,936.4** | **136.4** |

*Эх сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт орлогын дүн өсөхөд тайлант онд албан хаагчдын цалин хөлсний доод хэмжээ, бараа материалын үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалан татварын орлого 182.9 сая төгрөг, татварын бус орлого 186.3 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 359.6 сая төгрөгөөр нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,255.5 сая төгрөгийн орлогын давхардсан 8 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 2,177.0 сая төгрөгийн орлогын давхардсан 13 гүйлгээг хоорондын тооцоо дансаар устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.5.9 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 2,384.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 513.7 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар өссөн байна.

Хүснэгт № 10. Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Бараа ажил үйлчилгээний зардал | 1,822,768.5 | 2,347,244.1 | 524,475.6 | 128.8 |
| Урсгал шилжүүлэг | 48,010.0. | 37,251.8 | (10,758.2) | 77.6 |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **1,870,778.5** | **2,384,495.9** | **513,717.4** | **127.5** |

*Эх сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан*

Үйл ажиллагааны зардлын дүн өссөн нь цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн болон бараа үйлчилгээний зардлын дүн нэмэгдсэн зэрэг нь нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,255.5 сая төгрөгийн орлогын давхардсан 8 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 2,177.0 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээг хоорондын тооцоо дансаар устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын төсвийн төслийн зардлыг 2,985,7, сая төгрөгөөр төлөвлөж нэгтгэн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 22 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр,171 арга хэмжээнд зориулан 1,849.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,777.7 сая төгрөгийг урсгал зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 71.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 286.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 754.0 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 601.7 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 71.4 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 64.2 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 479.6 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 2,328.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/626 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар Жаргалант сумын ЕБС-ийн ашиглалтын зардалд 1.5 сая төгрөгийн нэмэх зохицуулалт хийж ТТЗ-ийн төсвийг 2,330.3 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.

**3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл:** Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 70.5 сая төгрөгийг, орон нутгийн орлогоос 1,850.5 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 345.0 сая төгрөг, нийт 2,266.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

**Сумын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:**

Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 671.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 857.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 27.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 20,000.0 | 19,172.4 | (827.6) | **95.9** |
| Цалин хөлс түүнтэй адилтгах орлого | 275,000.0 | 336,697.3 | 61,697.3 | 122.4 |
| ХХОАТ буцаалт | (26,609.8) | (26,609.8) | - | 100.00 |
| Хөрөнгийн орлого | 48,000.0 | 44,231.8 | (3,768.2) | 92.10 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 3,140.0 | 1,654.0 | (1,804.0) | 42.50 |
| Шууд бус орлого | 1,000.0 | 2,398.8 | 1,486.0 | 239.90 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 12,820.0 | 11,529.2 | (1,290.8) | 89.90 |
| Бууны албан татвар | 3,100.0 | 4,500.0 | 1,400.0 | 145.20 |
| Малд ногдуулах албан татвар | 48,000.0 | 53,340.9 | 5,340.9 | 111.10 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 11,000.0 | 40,698.7 | 29,698.7 | 370.00 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 500.0 | 4,358.5 | 3,858.5 | 871.70 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 7,080.0 | 9,667.5 | 2,587.5 | 136.5 |
| Газрын төлбөр | 7,830.0 | 16,832.0 | 9,002.0 | 215.0 |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 249,117.3 | 328,869.9 | 79,752.6 | 132.0 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 930.0 | 496.8 | (433.2) | 53.4 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 1,207.0 | 1,677.0 | 470.0 | 138.9 |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 3,600.0 | 483.8 | (3,116.2) | 13.4 |
| Торгуулийн орлого | 5,000.0 | 7,189.5 | 2,189.5 | 143.80 |
| Түрээсийн орлого | 400.0 | 444.0 | 44.0 | 111.0 |
| ТӨСВИЙН ОРЛОГО | **671,114.5** | **857,632.3** | **186,287.0** | **127.79** |

*сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн байдлын тайлан*

Жаргалант сумын орон нутгийн орлого 186.5 сая төгрөгөөр давж биелэхэд Хувь хүний орлого 57.0 сая төгрөгөөр, хөрөнгийн татвар 5.4 сая төгрөгөөр, бусад нийтлэг төлбөр хураамжийн орлого 36.1 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 76.7 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна. Энэ нь цалин хөлсний орлогыг нэмсэн болон самрын олборлолттой холбоотой байна.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 29.5 сая төгрөгөөр төлөвлөж 37.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 7.8 сая төгрөг буюу 26.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №11: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ААНОАТ | 5,000.0 | 0 | -5,000.0 | 0 |
| 2 | Автотээвэр болон ӨЯХАТ | 18,000.0 | 28.899.4 | 10,899.4 | 160.5 |
| 3 | Зам ашигласны төлбөр | 6,500.0 | 8,073.1 | 1,573.1 | 124.2 |
| 4 | Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | - | 344.0 | 344.0 | 0 |
| 5 | Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар | - | 17.3 | 17.3 | 0 |
| | **Нийт дүн** | **29,500.0** | **37,333.8** | **7,833.8** | **126.5** |

*Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого давж биелэхэд авто тээврийн хэрэгслийн татварын орлогын гүйцэтгэл гол нөлөөг үзүүлсэн байна. ААНОАТ-ын орлогыг төлөвлөсөн болович гүйцэтгэлийн хуваарилалтыг аймагт нэгдсэн дүнгээр бүртгэж, сум бүрээр хуваарилаагүй байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 191.3 сая төгрөгөөр төлөвлөж 124.2 сая төгрөг төвлөрч, 67.1 сая төгрөгөөр тасарсан байна. Татварын орлогын төлөвлөгөө 64.9 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Хүснэгт №12: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 40,055.5 | 26,286.0 | -13,769.5 | 65.6 |
| 2 | Дотоод бараа үйлчилгээний НӨАТ | 150,256.8 | 93,058.5 | -57,198.3 | 61.9 |
| 3 | Агаарын бохирдлын төлбөр | 970.0 | 4,868.7 | 3,898.7 | 501.8 |
| | **Нийт дүн** | **191,282.3** | **124,213.2** | **-67,069.1** | **64.94** |

Эх сурвалж:Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

<u>Илрүүлэлт:</u> Төсвийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

- *Орон нутгийн төсвийн орлогоос* үйл ажиллагааны орлогын татвар 0.8 сая төгрөг, хөрөнгийн орлого 3.4 сая төгрөг, байгалийн ургамал ашигласны төлбөр 3.1 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 1.8 сая төгрөг тасарсан байна.
- *Улсын төсвийн орлогоос* ААНОАТ-ын орлого 13.8 сая төгрөгөөр, НӨАТ-ын орлого 57.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь улсын төсвийн төлөвлөгөөний төслийг хийж батлуулан төлөвлөгөөний хуваарийг аймгийн Татварын хэлтэс нэгдсэн байдлаар хийж, сумдад хуваарилдаг байна.

Төсвийн орлогыг нийт дүнгээр авч үзвэл тайлант онд 891.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,019.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 127.3 сая төгрөг давж биелсэн ба 114.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

| Төсөв | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн төсөв | 671,114.50 | 857,632.30 | 186,517.80 | 127.8 |
| Аймгийн төсөв | 29,500.00 | 37,333.80 | 7,833.80 | 127.8 |
| Улсын төсөв | 191,282.30 | 124,213.20 | -67,069.10 | 64.9 |
| **Нийт дүн** | **891,896.80** | **1,019,179.30** | **127,282.50** | 114.3 |

Улсын төсөв, аймгийн төсөв, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн болович татварын орлогын нэр төрлөөр авч үзэхэд нэр бүхий орлогууд тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

**Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар**

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 2,330.4 сая төгрөгөөр төлөвлөж, 2,266.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн

зээлийн хүү 11.4 сая төлөвлөж, гүйцэтгэлээр 5.7 сая төгрөг орсон. Зээлийн эргэн төлөлт 60.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 64.8 сая төгрөгийн үндсэн зээл төвлөрч, нийт 70.5 сая төгрөгийн зээл болон зээлийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

**Төсвийн зарлагын талаар:**

Тайлант онд Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 6 хөтөлбөр, 171 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,330.4 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.
Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 2,057.5 сая буюу 88.2 хувь байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал:

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,057.5 сая төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 19.7 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7.6 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 18.8 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 1.6 сая төгрөг
- Томилолтын зардалд 0.1 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 124.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 2.6 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 67.4 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 10.8 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 8 төсөл арга хэмжээнд 449.5 сая төгрөг батлагдсанаас 7 төсөл арга хэмжээнд 379.8 сая төгрөгийг зарцуулж 70.6 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Сумын төвийн гэрэлтүүлгийн ажил дутуу хийгдэж, хөрөнгөөр хүлээн аваагүй.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 2,057.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 75 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 3.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 293.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.0 сая төгрөг нийт 297.7 сая төгрөгийн орлого оржээ.

Нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг авч үзвэл бичиг хэргийн зардал 0.4 сая төгрөг тээвэр шатахуун 1.6 сая төгрөг урсгал засвар 8.5 сая төгрөг томилолтын зардал 0.7 сая төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамж 175.5 сая төгрөг даатгалын үйлчилгээ 0.4 сая төгрөг бараа үйлчилгээний бусад зардал 29.1 сая төгрөг нэг удаагийн шагнал урамшуулал 3.3 сая төгрөг, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

**Худалдан авах ажиллагааны үр дүнгийн талаар**

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцад нийт 665.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 541.1 сая төгрөгийн үнийн саналтай 16 ажилд гэрээ байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагааг

зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 10, харьцуулалтын аргаар 9 тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 15 ажил үйлчилгээнд шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд 3.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТТЗ-ийн 2023 оны төсөвтэй хамт батлуулсан байна.

Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Жаргалант сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/81 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 73.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 58.5 сая төгрөгөөр тогтоосон.

Өмнөх онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой үйл ажиллагааны бус зардлын дүн өндөр байсантай холбоотой тайлант оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос материаллаг хэмжээгээр буурсан тул Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,870.8 сая төгрөгийг сонгож 29.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТТЗ-ийн худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 онд гүйцэтгэх завсрын үеийн санхүүгийн аудитын төлөвлөгөөнд тус байгууллагыг хамруулаагүй тул завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй болно

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 163.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт № 14 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Акт** | - | - | - | - | - |
| **Албан шаардлага** | - | - | - | - | - |
| **Зөвлөмж** | 2 | 163.0 | 2 | 163.0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **163.0** | **2** | **163.0** | **100** |

*Мэдээллийн эх сурвалжийг fas.audit.mn системээс авав.*

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 163.0 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 1 аж ахуй нэгж, 2 тусгай сан нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 1 аж ахуй нэгж түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

***Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил***

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 8.0 сая төгрөгийн алдаа, Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгө, газрын баримт бичиг дутуу, газрын хэмжээ буруу бүртгэсэн 3 зөрчил илэрсэн. Аудитын явцад 8.0 сая төгрөгийн алдааг залруулж, дээрх зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

***Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил***

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 159.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн.

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

**5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар**

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 35 иргэнтэй холбоотой 81.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. **Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Орон нутгийн орлогыг 7.3 сая төгрөгөөр, улсын төсвийн орлогыг 70.9 сая төгрөгөөр нийт 78.2 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд хангаж биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Харьяа байгууллагуудын алдаа Жаргалант ИТХ** | | | | | | | | |
| Бүртгэл тайлагналын алдаа | 1 | 8.0 | | | 1 | 8.0 | 1 | 8.0 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлого бүрдүүлэлттэй холбоотой | 1 | 78.2 | | | | | 1 | 78.2 | | | | |
| Хугацаа хэтэрсэн зээлийн авлага | 1 | 81.3 | | | | | 1 | 81.3 | | | | |
| **Дүн** | **2** | **159.5** | | | | | **2** | **159.5** | | | | |
| **Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/** | | | | | | | | | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгө | 1 | | | | | | 1 | | | | | |
| Газрын баримт бичиг дутуу | 1 | | | | | | 1 | | | | | |
| Газрын хэмжээг буруу бүртгэсэн | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **3** | | | | | | **1** | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР Б.ДАВААНЯМ

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР Д.ОТГОНБАЯР ОГНОО: